

**Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг хөгжүүлэх төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, хийгдсэн ажлууд**

2015-11-19

| № | Сургалтын агуулга                   | Оролцогчид   | Сургалт болсон хугацаа |
|---|-------------------------------------|--|------------------------|
| 1 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалт    | СЗХ-ны 21 хянан шалгагчид  | 2015.04.27-04.29       |
| 2 | Хөрөнгө оруулагчийн боловсрол       | СЗХ, зохицуулалттай байгууллагууд, нийт 30 хүн   | 2015.05.21             |
| 3 | Өөрийгөө зохицуулах байгууллага     | МХБ, ҮЦТТТХТ, МҮЦАЭХ, нийт 30 хүн  | 2015.05.21             |
| 4 | IPO болон Давхар бүртгэл            | ТОП-100 компани, үнэт цаасны компани, ЗГ болон холбогдох агентлаг, мэргэжлийн холбоод, хөрөнгө оруулагчид, 140 хүн | 2015.06.23             |
| 5 | Үнэт цаасны компанийн хянан шалгалт | СЗХ-ны 14 ажилтан  | 2015.09.30-10.10       |
| 6 | Өөрийгөө зохицуулах байгууллага     | МХБ, ҮЦТТТХТ, МҮЦАЭХ, 12 хүн   | 2015.11.10             |

1. Уг төслийн зөвлөх ноён А.Наканиши Хорооны ажилтнууд болон зохицуулалттай байгууллагын төлөөлөлд зориулж “Санхүүгийн боловсролын ач холбогдол, Оролцогч байгууллагуудын үүрэг, зорилтууд, Олон улсын туршлага ба харьцуулалт, Монгол Улсад хэрэгжүүлэх зөвлөмжүүд” сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд их, дээд сургуулиудын удирдлагатай уулзалт хийж энэ асуудлаар Хороотой хамтран ажиллах гарцуудыг зөвлөсөн.

2. Жайка-аас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Япон улсын Санхүүгийн үйлчилгээний агентлагаас Хорооны хянан шалгагч нарт зориулсан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сэдэвт сургалтыг 2015 оны 4 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулсан.

3. Төслийн зөвлөхүүд болох А.Наканиши, Х.Канеко нар нь Монголын хөрөнгийн биржид зориулан Өөрийгөө зохицуулах байгууллага /ӨЗХ/ сэдэвт сургалтыг 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан ба Хороо болон ӨЗБ-ын хүлээх чиг үүргийн хуваарилалтын загварыг гаргаж өгсөн.

4. СЗХ, ЖАЙКА болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран Монголын хөрөнгийн зах зээлийн чадавхижуулах төслийн хүрээнд “IPO болон Давхар бүртгэл” сэдэвт семинарыг 2015 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Уг семинарт Монголын ТОП-100 компаниуд, үнэт цаасны компани, Засгийн газар болон холбогдох агентлаг, мэргэжлийн холбоод, олон улсын агентлагууд болон

хөрөнгө оруулагчдын төлөөллүүд оролцсон. Мөн зөвлөхүүд төрийн өмчийг хувьчлах Ажлын хэсгийн хуралдаанд 2 удаа оролцож, зөвлөмжүүдийг өгсөн.

5. Үнэт цаасны компанийн хянан шалгалт сэдвээр Хорооны 14 ажилтныг хамруулсан 10 хоногийн сургалтыг Токио хотод зохион байгуулсан байна.

6. Өөрийгөө зохицуулах байгууллагын эрх үүргийн чиглэлээр харилцан зөвшилцөх сэдвээр төслийн зөвлөх А.Наканиши, Х.Канеко нар СЗХ, МХБ, МҮЦАЭХ-ны хамтарсан уулзалт хийсэн бөгөөд цаашид хийх ажлын уулзалтын төлөвлөгөөг тодорхойлоод байна.

7. Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн асуудлаар түүний хуралдаанд оролцох болон бие даасан байдал, ажлын чиг үүргийн талаар зөвлөмжүүдийг удаа дараа өгөөд байна.